

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2026 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН



УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

2026 ОНЫ 06 ДУГААР САРЫН 03-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС,
ХӨДӨӨ АЖ АХУЙН
БАЙНГЫН ХОРОО

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ГАЗАР

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дээрх
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2026 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ
БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН
АГУУЛГА**

2026 оны 06 дугаар сарын 03-ны өдөр, Лхагва гараг

	<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
	<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	2 – 21
	<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	22 – 55
1.	<i>Хөдөө аж ахуйн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн М.Мандхай нарын 10 гишүүн 2025 оны 06 сарын 19-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/</i>	23 – 46
2.	<i>Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /Засгийн газар 2026 оны 05 сарын 21-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/</i>	46 – 55

**Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы
Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны
06 дугаар сарын 03-ны өдөр /Лхагва гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаясгалан ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 29 гишүүнээс 16 гишүүн хүрэлцэн ирж, 55.2 хувийн ирцтэйгээр хуралдаан 16 цаг 42 минутад Төрийн ордны “Үндсэн хууль” танхимд эхлэв.

Томилолттой: Б.Бейсен, Д.Батбаяр, Г.Ганбаатар, М.Ганхүлэг, Д.Жаргалсайхан, Ц.Туваан, А.Ундраа;

Чөлөөтэй: Н.Алтаншагай, Д.Амарбаясгалан, С.Замира, У.Отгонбаяр.

Нэг.Хөдөө аж ахуйн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн М.Мандхай нарын 10 гишүүн 2025 оны 06 сарын 19-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Есөн-Эрдэнэ, мөн яамны Хуулийн хэлтсийн дарга Ч.Раднаабазар, Бодлого, төлөвлөлтийн газрын шинжээч Ц.Мөнхнасан нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, зөвлөх Бад.Баярмаа, Ж.Түвшинжаргал, референт Б.Бадралт, Ц.Рэнцэнтогтох, Б.Энхгэрэл нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын дэд дарга Ж.Бат-Эрдэнэ танилцуулав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Хөдөө аж ахуйн тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.

-Хөдөө аж ахуйн тухай хуулийн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

Л.Мөнхбаясгалан: 1.Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ, Д.Жаргалсайхан, С.Замира, С.Лүндэг, Н.Наранбаатар, Р.Сэддорж /Цаашид “Ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1.1.Энэ хуулийн зорилт нь төрөөс хөдөө аж ахуйг тогтвортой хөгжүүлэх бодлогын дэмжлэгтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 8
Бүгд: 16
50.0 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Р.Сэддоржийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Л.Мөнхбаясгалан: Улсын Их Хурлын гишүүн Р.Сэддоржийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 6
Бүгд: 16
62.5 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Л.Мөнхбаясгалан: Төслийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1.1.Энэ хуулийн зорилт нь төрөөс хөдөө аж ахуйг тогтвортой хөгжүүлэх бодлогын дэмжлэгтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 5
Бүгд: 16
68.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

-Төслийн 1 дүгээр зүйлийг хэлэлцэж дууслаа.

-Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

Л.Мөнхбаясгалан: 2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн “Малын тоо толгойн албан татварын тухай хууль” гэсний өмнө “Гамшгаас хамгаалах тухай хууль,” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 5
Бүгд: 16

68.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

-Төслийн 2 дугаар зүйлийг хэлэлцэж дууслаа.

-Төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

Л.Мөнхбаясгалан: 3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсгийн “өртгийн” гэснийг “үйлдвэрлэлийн” гэж өөрчлөн, цаашид тохиолдол бүрт өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10

Татгалзсан: 6

Бүгд: 16

62.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

-Төслийн 3 дугаар зүйлийг хэлэлцэж дууслаа.

-Төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

Л.Мөнхбаясгалан: 4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4 дүгээр зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1.“хөдөө аж ахуйн үйлдвэрлэл” гэж хөдөө аж ахуйн газарт байгалийн болон биологийн нөөцөд тулгуурлан мал аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэл дагнан, эсхүл хослуулан эрхлэх үйл ажиллагааг;

4.1.2.“мал аж ахуйн үйлдвэрлэл” гэж мал, амьтныг өсгөн үржүүлж, тэдгээрээс гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг бэлтгэн нийлүүлэх, үйлдвэрлэх үйл ажиллагааг;

4.1.3.“тариалангийн үйлдвэрлэл” Тариалангийн тухай хуулийн 16.1-д заасныг;

4.1.4.“бэлчээрийн мал аж ахуй” гэж мал сүргийг бэлчээрт жилийн туршид улирлын хуваарьтайгаар идээшлүүлэн маллаж, ашиг шимийг нь хүртдэг, нүүдлийн өв соёлыг хадгалсан уламжлалт мал аж ахуйн үйлдвэрлэлийг;

4.1.5.“эрчимжсэн мал аж ахуй” гэж Тариалангийн тухай хуулийн 3.1.7-д заасныг;

4.1.6. “хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн” гэж хүнсний болон аж үйлдвэрийн зориулалтаар ургамал, мал, тэжээвэр амьтны аж ахуйгаас үйлдвэрлэсэн түүхий эд, бүтээгдэхүүнийг;

4.1.7. “агро-ойн аж ахуй” гэж ойжуулалтыг хөдөө аж ахуйн үйлдвэрлэлтэй зориудаар хослуулсан, нийгэм, эдийн засаг, байгаль орчны ашиг тустай аж ахуйн зохион байгуулалтыг;

4.1.8. “хөдөө аж ахуйн аялал жуулчлал” гэж мал аж ахуй, газар тариалан, уламжлалт нүүдлийн ахуйн хэв маяг, үндэсний соёл, өв уламжлалыг хадгалах, сурталчлан таниулах аялал жуулчлалын төрлийг;

4.1.9. “хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгч” гэж энэ хуулийн 4.1.1-д заасан үйл ажиллагааг эрхэлж, эдийн засгийн өгөөж хүртэж байгаа хувь хүн, хуулийн этгээдийг;

4.1.10. “тогтвортой хөдөө аж ахуй” гэж хүн, байгаль орчинд ээлтэй, нийгмийн хариуцлагатай, байгалийн нөөцийн зохистой ашиглалт, эдийн засгийн өгөөжтэй, урт хугацаанд үргэлжлэх, бүтээмжтэй хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг;

4.1.11. “хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн сүлжээ” гэж хөдөө аж ахуйн түүхий эд, бүтээгдэхүүн үйлдвэрлэх, бэлтгэн нийлүүлэх, анхан шатны боловсруулалт хийх, хадгалах, тээвэрлэх, борлуулах цогц үйл ажиллагааг.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10

Татгалзсан: 6

Бүгд: 16

62.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

-Төслийн 4 дүгээр зүйлийг хэлэлцэж дууслаа.

-Төслийн 5 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

Л.Мөнхбаясгалан: 5.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийн “хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн тогтвортой хөгжлийг хангах,” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10

Татгалзсан: 6

Бүгд: 16

62.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

6.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 5 дугаар зүйлийн 5.2.4 дэх заалтын “инноваци, дэвшилтэт шинэ технологийг” гэснийг “инновацыг” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11

Татгалзсан: 5

Бүгд: 16

68.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

7.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 5 дугаар зүйлийн 5.2.5 дахь заалтын “хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд” гэснийг, 5.2.6 дахь заалтын “хөдөө аж ахуйн хөдөлмөрийн үнэлэмж,” гэснийг, 5.2.7 дахь заалтын “түүхий эд” гэсний өмнөх “хөдөө аж ахуйн” гэснийг, 5.2.8 дахь заалтын “залгамж халааг тасралтгүй бэлтгэх тогтолцоог бэхжүүлэх” гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10

Татгалзсан: 6

Бүгд: 16

62.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

8.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 5 дугаар зүйлийн 5.2.9 дэх заалтын “хувийн хэвшил,” гэснийг “хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан,” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11

Татгалзсан: 5

Бүгд: 16

68.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

-Төслийн 5 дугаар зүйлийг хэлэлцэж дууслаа.

-Төслийн 6 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

Л.Мөнхбаясгалан: 9.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 6 дугаар зүйлийн 6.1.2 дахь заалтын “тариалан” гэсний өмнө “газар” гэж, 6.3 дахь хэсгийн “тариалангийн” гэсний өмнө “газар” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11

Татгалзсан: 5

Бүгд: 16

68.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

10.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 6 дугаар зүйлийн 6.2.5, 6.2.6 дахь заалтыг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11

Татгалзсан: 5

Бүгд: 16

68.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

11.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 6 дугаар зүйлийн 6.4, 6.5 дахь хэсгийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 7

Бүгд: 16

56.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

-Төслийн 6 дугаар зүйлийг хэлэлцэж дууслаа.

-Төслийн 7 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

Л.Мөнхбаясгалан: **12.**Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 7 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“7 дугаар зүйл.Хөдөө аж ахуйг төрөлжүүлэн хөгжүүлэх

7.1.Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын хүрээнд газар зүйн байршил, экологийн онцлог, дэд бүтцийн хөгжил, хүн амын нягтрал болон биологийн бусад нөөц, зах зээлийн эрэлтэд тулгуурлан төрөлжүүлэн хөгжүүлнэ.

7.2.Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг төрөлжүүлэн хөгжүүлэх тэргүүлэх чиглэлд бэлчээрийн болон эрчимжсэн мал аж ахуй, тэжээл үйлдвэрлэл, жимс, жимсгэнэ, хүнсний ногоо, үр тариа, хамгаалагдсан хөрсний тариалан, үржлийн аж ахуй, агро-ойн аж ахуйг хөгжүүлэх асуудлыг тусгайлан хамааруулна.

7.3.Хөдөө аж ахуйг төрөлжүүлэн хөгжүүлэх асуудлыг Хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тодорхойлж, орон нутгийн хөгжлийн бодлого, Засаг даргын мөрийн хөтөлбөрт тусган хэрэгжүүлнэ.

7.4.Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг хоршоо, кластерын зохион байгуулалтаар болон хөдөө аж ахуйн захиалгат бүтээгдэхүүн үйлдвэрлэлээр төрөлжүүлэн хөгжүүлж болно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11

Татгалзсан: 5

Бүгд: 16

68.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

-Төслийн 7 дугаар зүйлийг хэлэлцэж дууслаа.

-Төслийн 8 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Ганбаатарын тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын дэд дарга Ж.Бат-Эрдэнэ хариулж, тайлбар хийв.

Л.Мөнхбаясгалан: 13.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 8 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“8 дугаар зүйл.Хөдөө аж ахуйн түүхий эд, бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэлтийн тогтолцоо

8.1.Хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг төвлөрүүлэх, хадгалах, чанар хамгаалалт хийх, худалдан борлуулах төвийг аймаг, суманд байгуулна.

8.2.Энэ хуулийн 8.1-д заасан төвийн үйл ажиллагааг төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлнэ.

8.3.Энэ хуулийн 8.1-д заасан төвд нийлүүлж, худалдан борлуулж байгаа түүхий эд, бүтээгдэхүүний талаарх мэдээлэл нь хөдөө аж ахуйн биржийн болон энэ хуулийн 10.1-д заасан цахим сантай холбогдсон байна.

8.4.Энэ хуулийн 8.1-д заасан төв нь түүхий эд, бүтээгдэхүүнийг худалдан авах, холбогдох стандарт, техникийн зохицуулалтын шаардлагын дагуу чанараар ангилах, шаардлагатай анхан шатны тордолт хийх, багцлах, савлах, шошголох, хадгалах, худалдан борлуулах үйл ажиллагааг хариуцан гүйцэтгэнэ.

8.5.Энэ хуулийн 8.1-д заасан төвийг байгуулах санхүүжилтийн эх үүсвэрийг улсын болон аймаг, сумын төсөв, хувийн хэвшлийн санхүүжилтээр /түншлэлээр/ шийдвэрлэнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 7

Бүгд: 16

56.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

-Төслийн 8 дугаар зүйлийг хэлэлцэж дууслаа.

-Төслийн 9 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

Л.Мөнхбаясгалан: 14.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 9 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“9 дүгээр зүйл.Хөдөө аж ахуйн түүхий эд, бүтээгдэхүүний чанарын үнэлгээ, баталгаажуулалт

9.1.Хөдөө аж ахуйн түүхий эд, бүтээгдэхүүний чанарыг холбогдох стандартын дагуу үнэлж, баталгаажуулна.

9.2.Аймаг бүр хөдөө аж ахуйн гаралтай хүнсний бус түүхий эд, бүтээгдэхүүний чанарыг шинжлэн судалдаг зориулалтын тоног төхөөрөмж, мэргэшсэн шинжээч бүхий лабораторитой байна.

9.3.Хөдөө аж ахуйн гаралтай хүнсний эрүүл ахуй, чанарын шинжилгээг холбогдох хуулиар зохицуулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 7

Бүгд: 16

56.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

-Төслийн 9 дүгээр зүйлийг хэлэлцэж дууслаа.

-Төслийн 10 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

Л.Мөнхбаясгалан: 15.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 10 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“10 дугаар зүйл.Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн сүлжээний бүртгэл, мэдээлэл

10.1.Хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь хүнсний бүтээгдэхүүний, зөвшөөрлийн, мал аж ахуй, газар тариалангийн, малын генетик нөөц, мал, амьтан, ургамлын эрүүл мэндийн, түүхий эд, бүтээгдэхүүний гарал үүслийн, дотоодын болон олон улсын худалдаа, үйлчилгээний цахим сан (цаашид “цахим сан” гэх)-тай байна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 7

Бүгд: 16

56.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Төслийн 10 дугаар зүйлийг хэлэлцэж дууслаа.

-Төслийн 11 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 12 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Ганбаатарын тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын дэд дарга Ж.Бат-Эрдэнэ хариулж, тайлбар хийв.

Л.Мөнхбаясгалан: 16.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 12 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“12 дугаар зүйл.Тогтвортой хөдөө аж ахуйн төлөвлөлт

12.1.Тогтвортой хөдөө аж ахуйг хөгжүүлэх Хөгжлийн зорилтот хөтөлбөртэй байна.

12.2.Хөдөө аж ахуйн хөгжлийн зорилтот хөтөлбөрт дараах асуудлыг тусгана:

12.2.1.хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг төрөлжүүлэн хөгжүүлэх;

12.2.2.хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд шаардагдах мэргэшсэн хүний нөөцийн хэрэгцээг мэргэжил, мэргэшлийн түвшнээр тодорхойлж, хангах арга хэмжээ;

12.2.3.дотоодын хүнсний хангамж, экспортын бүтээгдэхүүний нийлүүлэлт, борлуулалт;

12.2.4.түүхий эд, бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэлт;

12.2.5.хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний экспортын зах зээлийг судалж, экспортын голлох бүтээгдэхүүн тус бүрээр бодлого, стратеги;

12.2.6.хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг ашигтай эрхлэх зах зээлийн болон нийгмийн таатай орчин бүрдүүлэлт.

12.3.Хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн энэ хуулийн 12.1-д заасан зорилтот хөтөлбөрийг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нийцүүлэн батлуулж, хэрэгжилтийг хангана.

12.4.Хөдөө аж ахуйн салбарт хэрэгжүүлж байгаа олон улсын төсөл, хөтөлбөрт энэ хуулийн 12.1-д заасан хөгжлийн зорилтот хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр тусгана.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	9
Татгалзсан:	7
Бүгд:	16

56.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Л.Мөнхбаясгалан: 17.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 13 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“13 дугаар зүйл.Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн газар

13.1.Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэх баталгааг дэмжих зорилгоор төрөөс холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчид газрыг ашиглах, эзэмших нөхцөлийг бүрдүүлнэ.

13.2.Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах уст цэг, худгийн хоорондох зайг усны нөөц, уст цэгийн хайгуулын дүн, бүс нутгийн газар зүйн онцлогт үндэслэн аймаг, нийслэлийн Засаг дарга тогтооно.

13.3.Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн хэрэгцээний усны нөөц, уст цэгийн хайгуул, судалгаа хийх, хэрэгжүүлэхтэй холбогдох харилцааг Усны тухай хуулиар зохицуулна.

13.4.Хөдөө аж ахуйн газрын ангиллыг өөрчлөх, ангилал шилжүүлэх тохиолдолд Газрын тухай хуулийн 23.2.9-д заасныг баримтлах бөгөөд улсын хөгжлийн бодлогын зайлшгүй шаардлагатайгаас бусад тохиолдолд хөдөө аж ахуйн газрыг нэгдмэл сангийн өөр ангилалд шилжүүлэхгүй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 7

Бүгд: 16

56.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

-Төслийн 13 дугаар зүйлийг хэлэлцэж дууслаа.

-Төслийн 14 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

Л.Мөнхбаясгалан: 18.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн “Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн хүний нөөц” гэсэн 14 дүгээр зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10

Татгалзсан: 6

Бүгд: 16

62.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

-Төслийн 14 дугаар зүйлийг хэлэлцэж дууслаа.

-Төслийн 15 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

Л.Мөнхбаясгалан: 19.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 15 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“15 дугаар зүйл.Хөдөө аж ахуйн судалгаа ба хөгжүүлэлт

15.1.Хөдөө аж ахуйн судалгаа ба хөгжүүлэлтийн тогтолцоо нь дэвшилтэт технологи, инновацыг нэвтрүүлэх, оюуны өмчөөр хамгаалагдсан мэдлэгийг эргэлтэд оруулах, зах зээлд гаргах, энэ хуулийн 12.1-д заасан зорилтот хөтөлбөрт тусгасан судалгаа, хөгжүүлэлтийг гүйцэтгэхэд чиглэгдэнэ.

15.2.Хөдөө аж ахуйн салбарын шинжлэх ухаан, технологи, инновацийн судалгааны үр дүнг нэвтрүүлэх, зөвлөх үйлчилгээ үзүүлэх, сургалт, сурталчилгаа зохион байгуулах чиг үүрэгтэй төрийн үйлчилгээний байгууллага хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэд ажиллана.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10

Татгалзсан: 6

Бүгд: 16

62.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

-Төслийн 15 дугаар зүйлийг хэлэлцэж дууслаа.

-Төслийн 16 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын дэд дарга Ж.Бат-Эрдэнэ үг хэлэв.

Л.Мөнхбаясгалан: 20.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 16 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“16 дугаар зүйл.Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн эрсдэл, түүнээс урьдчилан сэргийлэх

16.1.Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээний нэгдсэн удирдлагыг хэрэгжүүлнэ.

16.2.Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн эрсдэлийг доор дурдсан ангиллын дагуу үнэлэх, урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

16.2.1.байгаль орчны;

16.2.2.эдийн засгийн;

16.2.3.нийгмийн.

16.3.Энэ хуулийн 16.2.1-д заасан нөлөөллийн эрсдэлд бэлчээрийн болон тариалангийн газрын доройтол, усны хомсдол, генетик нөөцийн төлөв, уур амьсгалын өөрчлөлт, хүлэмжийн хийн ялгаруулалт, хог хаягдлын менежмент хамаарна.

16.4.Энэ хуулийн 16.2.2-т заасан нөлөөллийн эрсдэлд хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн эрэлт, нийлүүлэлтийн тэнцвэр, бүтээмж, өрсөлдөх чадвар, эдийн засгийн өгөөж, түүхий эд, бүтээгдэхүүний үнийн хэлбэлзэл, санхүүжилтийн хүртээмж, төрийн дэмжлэгийн үр дүн хамаарна.

16.5.Энэ хуулийн 16.2.3-т заасан нөлөөллийн эрсдэлд хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчийн тогтвортой ажлын байр, ажиллах орчны аюулгүй байдал, нийгмийн баталгааны өөрчлөлтөд дасан зохицох чадамж хамаарна.

16.6.Хөдөө аж ахуйн салбарын өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах, байгалийн эрсдэлээс сэргийлэх, хамгаалах арга хэмжээг Засгийн газар болон орон нутгийн засаг захиргаа авч, хэрэгжилтэд хяналт тавина.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 10

Татгалзсан: 6

Бүгд: 16

62.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

-Төслийн 16 дугаар зүйлийг хэлэлцэж дууслаа.

-Төслийн 17 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

-Төслийн 18 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Ганбаатарын тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын дэд дарга Ж.Бат-Эрдэнэ үг хэлэв.

Л.Мөнхбаясгалан: 21.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 18 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“18 дугаар зүйл.Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн дэмжлэг

18.1.Хөдөө аж ахуйн дотоодын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, импортыг орлох болон экспортын баримжаатай түүхий эд, бүтээгдэхүүн үйлдвэрлэх бодлогын хүрээнд төрөөс дараах дэмжлэг үзүүлж болно:

18.1.1.шууд болон шууд бус татаас;

18.1.2.тарифын болон тарифын бус зохицуулалт;

18.1.3.хөнгөлөлттэй зээл, зээлийн хүүгийн хөнгөлөлт;

18.1.4.бусад.

18.2.Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн дэмжлэг үзүүлэх үйлдвэрлэлийн сүлжээний оролцогч нь дараах шаардлагыг хангасан байна:

18.2.1.зохистой дадал нэвтрүүлсэн, баталгаажуулсан;

18.2.2.стандарт, техникийн зохицуулалтын шаардлага хангасан, баталгаажуулсан;

18.2.3.чанараас хамаарсан үнийн тогтолцоог нэвтрүүлсэн;

18.2.4.үйлдвэрлэлийн бүтээмжийг нэмэгдүүлсэн байх;

18.2.5.импортыг орлох, экспортын баримжаатай үйлдвэрлэл байх;

18.2.6.нэмүү өртөг шингээсэн байх.

18.2.7.тухайн салбарын мэргэжлийн холбоодын саналыг авч, зөвшилцөн байх.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 7

Бүгд: 16

56.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

-Төслийн 18 дугаар зүйлийг хэлэлцэж дууслаа.

-Төслийн 19 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

Л.Мөнхбаясгалан: 22.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 19 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“19 дүгээр зүйл.Хөдөө аж ахуйн салбар дахь төрийн удирдлага, зохицуулалт

19.1.Хөдөө аж ахуйн салбарын төрийн бодлого нь төвлөрсөн байх бөгөөд улсын хэмжээнд хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэлд хүнс, хөдөө аж ахуйн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, сум, дүүрэгт хөдөө аж ахуйн тасаг болон бусад харьяа байгууллагаас бүрдэнэ.

19.2.Хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний эрхлэх асуудлын хүрээнд мал, таримал ургамлын генетик нөөц, ургамлын болон мал, амьтны эрүүл мэнд, гений сан, малын эм үйлдвэрлэл, лаборатори, аймаг дундын отрын бэлчээр, шинжлэх ухаан, инновац, судалгаа, шинжилгээ, нэвтрүүлэлт хариуцсан төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний байгууллага, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд тус тус ажиллана.

19.3.Аймаг, нийслэлийн хүнс, хөдөө аж ахуйн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, хөдөө аж ахуйн тасгийн бүтцийг Засгийн газраас тогтоосон орон тооны хязгаарт багтаан хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

19.4.Энэ хуулийн 19.2, 19.3-т заасан байгууллага нь энэ хуульд болон холбогдох бусад хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 7

Бүгд: 16

56.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

-Төслийн 19 дугаар зүйлийг хэлэлцэж дууслаа.

-Төслийн 20 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

Л.Мөнхбаясгалан: 23.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 20 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 7

Бүгд: 16

56.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

-Төслийн 20 дугаар зүйлийг хэлэлцэж дууслаа.

-Төслийн 21 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

-Төслийн 22 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

Л.Мөнхбаясгалан: 24.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 22 дугаар зүйлийн хуулийг дагаж мөрдөх хугацааг “2027 оны 01 дүгээр сарын 01” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8

Татгалзсан: 8

Бүгд: 16

50.0 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяагийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Л.Мөнхбаясгалан: Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяагийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 7

Бүгд: 16

56.3 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Л.Мөнхбаясгалан: Төслийн 22 дугаар зүйлийн хуулийг дагаж мөрдөх хугацааг “2027 оны 01 дүгээр сарын 01” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 7

Бүгд: 16

56.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

-Төслийн 22 дугаар зүйлийг хэлэлцэж дууслаа.

Л.Мөнхбаясгалан: 25.Ажлын хэсгийн гаргасан, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах /6 дугаар зүйлийн 6.5 дахь хэсэгт “6.5.9.хөдөө аж ахуйн зорилтот хөтөлбөр.” гэсэн заалт нэмэх/ гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 7

Бүгд: 16

56.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

26.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн нэр томъёог жигдлэх, зүйл, хэсэг, заалтын дугаарыг нийцүүлж өөрчлөх, бүтэц найруулга, хууль зүйн техникийн засварыг хийх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 7

Бүгд: 16

56.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Хөдөө аж ахуйн тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Хөдөө аж ахуйн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.

-Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Хөдөө аж ахуйн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.

-Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Хөдөө аж ахуйн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.

-Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Хөдөө аж ахуйн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын дэд дарга Ж.Бат-Эрдэнэ Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 17 цаг 45 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /Засгийн газар 2026 оны 05 сарын 21-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд С.Амарсайхан, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ш.Батбаяр, Эдийн засаг, хөгжлийн яамны Хөрөнгө оруулалтын бодлогын газрын дарга Б.Мөнх-Эрдэнэ, Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын Санхүүгийн зах зээл, олон улсын хамтын ажиллагааны хэлтсийн дарга Б.Амарбаясгалан, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Б.Бат-Өлзий, Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын Санхүүгийн зах зээл, олон улсын хамтын ажиллагааны ахлах мэргэжилтэн Б.Номин, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын ахлах шинжээч А.Нарангарав, Нэгдсэн Үндэстний Байгууллагын хөгжлийн хөтөлбөрийн хамтран хэрэгжүүлж буй Нүүрстөрөгчийн зах зээлийн бэлэн байдлыг бэхжүүлэх төслийн хуулийн зөвлөх Б.Номун оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, зөвлөх Бад.Баярмаа, Ж.Түвшинжаргал, референт Б.Бадралт, Ц.Рэнцэнтогтох, Б.Энхгэрэл нар байлцав.

Хууль санаачлагчийн илтгэлийг Хууль зүй, дотоод хэргийн сайд С.Амарсайхан танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Ганбаатарын тавьсан асуултад Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ш.Батбаяр хариулж, тайлбар хийв.

Л.Мөнхбаясгалан: Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 7

Бүгд: 16

56.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Л.Мөнхбаясгалан: Хамт өргөн мэдүүлсэн Агаарын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 7

Бүгд: 16

56.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Л.Мөнхбаясгалан: Авто замын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 7

Бүгд: 16

56.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8

Татгалзсан: 8

Бүгд: 16

50.0 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаясгалангийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Л.Мөнхбаясгалан: Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаясгалангийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 7

Бүгд: 16

56.3 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Л.Мөнхбаясгалан: Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 7

Бүгд: 16

56.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Л.Мөнхбаясгалан: Барилгын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 7

Бүгд: 16

56.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Л.Мөнхбаясгалан: Байгаль орчныг хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 7

Бүгд: 16

56.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Л.Мөнхбаясгалан: Гамшгаас хамгаалах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 7

Бүгд: 16

56.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Л.Мөнхбаясгалан: Олон улсын гэрээний тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 7

Бүгд: 16

56.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Л.Мөнхбаясгалан: Тариалангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 7

Бүгд: 16

56.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Л.Мөнхбаясгалан: Хот байгуулалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 7

Бүгд: 16

56.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Л.Мөнхбаясгалан: Статистикийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 7

Бүгд: 16

56.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Л.Мөнхбаясгалан: Эрчим хүчний хэмнэлтийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 7

Бүгд: 16

56.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Л.Мөнхбаясгалан: Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хуулийг дагаж мөрдөх тухай журмын тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 7

Бүгд: 16

56.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Л.Мөнхбаясгалан: Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 18 цаг 04 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 1 цаг 23 минут үргэлжилж, 29 гишүүнээс 18 гишүүн хүрэлцэн ирж, 62.1 хувийн ирцтэйгээр 18 цаг 05 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

БАЙГАЛЬ ОРЧИН,
ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН
БАЙНГЫН ХОРООНЫ
ДАРГА

Б.БЕЙСЕН

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН
БАЙГУУЛАХ ГАЗРЫН
ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2026 оны 06 дугаар сарын 03-ны өдөр, Лхагва гараг
Төрийн ордны “Үндсэн хууль” танхим
16 цаг 42 минут

БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Л.Мөнхбаясгалан: Эрхэм гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая.

Байнгын хорооны гишүүдийн олонх нь хүрэлцэн ирж ирц 55.2 хувьтай бүрдсэн тул Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны 2026 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдэж байна.

Хуралдаанд ирсэн гишүүдийг танилцуулъя.

Сайнбуянгийн Амарсайхан 13 дугаар тойрог ирсэн байна.
Пүрэвийн Батчимэг ирсэн байна.
Жадамбын Бат-Эрдэнэ 4 дүгээр тойрог ирсэн байна.
Бат-Өлзийн Бат-Эрдэнэ 4 дүгээр тойрог ирсэн байна.
Сайнхүүгийн Ганбаатар 1 дүгээр тойрог ирсэн байна.
Хассуурийн Ганхуяг 9 дүгээр тойрог ирсэн байна.
Сүрэнжавын Лүндэг 5 дугаар тойрог ирсэн байна.
Мэндбаярын Мандхай ирсэн байна.
Цагаанхүүгийн Мөнхбат 7 дугаар тойрог ирсэн байна.
Лувсанбямбаагийн Мөнхбаясгалан 7 дугаар тойрог ирсэн байна.
Тогтмолын Мөнхсайхан 12 дугаар тойрог ирсэн байна.
Нанзадын Наранбаатар 7 дугаар тойрог ирсэн байна.
Салдангийн Одонтуяа ирсэн байна.
Ренчинбямбын Сэддорж 7 дугаар тойрог ирсэн байна.
Болдын Уянга ирсэн байна.
Жигжидсүрэнгийн Чинбүрэн 8 дугаар тойрог ирсэн байна.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

-Нэгдүгээрт, Хөдөө аж ахуйн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл. Улсын Их Хурлын гишүүн М.Мандхай нарын 10 гишүүн 2025 оны 6 сарын 19-ний өдөр өргөн мэдүүлсэн. Анхны хэлэлцүүлэг.

-Хоёрдугаарт, Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл. Засгийн газар 2026 оны 5 сарын 21-ний өдөр өргөн мэдүүлсэн. Хэлэлцэх эсэх.

Хэлэлцэх эсэх асуудлын талаар саналтай гишүүн байна уу?

Хэлэлцэх асуудлын талаар саналтай гишүүн байхгүй тул хэлэлцэх асуудлаа баталлаа. /алх цохив/

Хэлэлцэх асуудалдаа оръё.

**Нэг.Хөдөө аж ахуйн тухай хуулийн төсөл болон
хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл**
/Улсын Их Хурлын гишүүн М.Мандхай нарын 10 гишүүн
2025 оны 06 сарын 19-ний өдөр өргөн мэдүүлсэн,
анхны хэлэлцүүлэг/

Хөдөө аж ахуйн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулна.

Хуралдаанд оролцож байгаа ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам. Д.Есөн-Эрдэнэ Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга, Ч.Раднаабазар Хуулийн хэлтсийн дарга, Ц.Мөнхнасан Бодлого, төлөвлөлтийн газрын шинжээч.

Төслийн анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх. Танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын дэд дарга Ж.Бат-Эрдэнэ танилцуулна.

Ж.Бат-Эрдэнэ гишүүний микрофоныг өгье.

Ж.Бат-Эрдэнэ: Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын гишүүн М.Мандхай нарын 10 гишүүнээс 2025 оны 06 дугаар сарын 19-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хөдөө аж ахуйн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг 2025 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж шийдвэрлэж анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд шилжүүлсэн болно.

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо дээрх хуулийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийг 2025 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 22 дугаар тогтоолоор байгуулсан бөгөөд ажлын хэсгийг Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ миний бие ахалж бүрэлдэхүүнд нь Улсын Их Хурлын гишүүн Д.Жаргалсайхан, С.Замира, С.Лүндэг, Н.Наранбаатар Р.Сэддорж нар ажиллалаа.

Энэ хугацаанд ажлын хэсэг гурван удаа мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх баг 9 удаа хуралдаж хөдөө аж ахуйн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн талаарх нийт 26 зарчмын зөрүүтэй санал, Хөгжлийн бодлого, төлөвлөлт түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулан саналын томьёоллыг бэлтгэлээ.

Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын хүрээнд газар зүйн байршил, экологийн онцлог, дэд бүтцийн хөгжил, хүн амын нягтрал болон биологийн бусад нөөц зах зээлийн эргэлтэд тулгуурлан төрөлжүүлэн хөгжүүлэх, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд чанараас хамаарсан үнийн тогтолцоог бүрдүүлэх, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хүний нөөцийн бодлого, судалгаа, хөгжлийг төлөвшүүлэх, хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчид, хөрөнгө оруулагчдыг дэмжих чиглэл, шалгуурыг тогтоох, бүртгэл, хяналтын нэгдсэн сүлжээг бий болгох, хөдөө аж ахуйн үйлдвэрлэл дэх төрийн бодлогын удирдлагын тогтолцооны цар хүрээг тогтоож, бүртгэл хяналтын нэгдсэн цахим систем бий болгох харилцааг зохицуулах.

Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд холбогдох зохистой дадал, стандарт, техникийн зохицуулалтыг мөрдөх шаардлагыг хангуулах, чанартай, уялдсан үнийн тогтолцоог хөгжүүлэхэд чиглэсэн төрийн дэмжлэг олгох, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн эрэлт, нийлүүлэлт, нөөц, ашиглалт, бүтээмжийн дүн шинжилгээ хийх, түүнд суурилсан тогтвортой хөгжүүлэх зорилт хөтөлбөрийг баталж хэрэгжүүлэх, орон нутгийн түвшинд уг зорилтот хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө гарган хэрэгжилтийг зохион байгуулах зэрэг зарчмын шинж чанартай зохицуулалтуудыг тусгалаа.

Мөн хөдөө аж ахуйн тухай хуулийн төслийн талаарх гаргасан зарчмын зөрүүтэй саналтай нийцүүлэн Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах, хууль зүйн техникийн болон найруулгын шинжтэй засваруудыг хийсэн болно.

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг Та бүхэнд тараасан болно.

Хөдөө аж ахуйн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Л.Мөнхбаясгалан: Ж.Бат-Эрдэнэ даргад баярлалаа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-д Байнгын хороо хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэнэ гэж заасны дагуу хэлэлцье.

Гишүүд Та бүхэн тухайн зүйлтэй холбогдуулан асуулт асууж болно.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Асуулт асуух гишүүн байхгүй байна. /алх цохив/

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1.1.Энэ хуулийн зорилт нь төрөөс хөдөө аж ахуйг тогтвортой хөгжүүлэх бодлогын дэмжлэгтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино.”

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ, Д.Жаргалсайхан, С.Замира, С.Лүндэг, Н.Наранбаатар, Р.Сэддорж. Цаашид “Ажлын хэсэг” гэх.

Санал хураалт. Гишүүд санал хураалтдаа бэлдээрэй. 1 дүгээр асуудлаар Санал хураалт. /алх цохив/

Горимын санал. Р.Сэддорж гишүүн горимын санал гаргая.

Р.Сэддорж: Миний төхөөрөмж ажиллахгүй байгаа учраас сүүлийн санал хураалтыг дахин явуулж өгнө үү?

Л.Мөнхбаясгалан: Р.Сэддорж гишүүний горимын саналын дагуу саяын санал хураалтыг хүчингүй болгоё гэснээр санал хураалт. /алх цохив/

62.5 хувиар горимын санал дэмжигдлээ.

Санал хураалтыг дахин явуулъя. /алх цохив/

68.8 хувиар санал хураалт дэмжигдлээ.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Асуулт асуух гишүүд байхгүй байна. /алх цохив/

2.Төслийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн “Малын тоо толгойн албан татварын тухай хууль” гэсний өмнө “Гамшгаас хамгаалах тухай хууль,” гэж нэмэх.

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

68.8 хувиар санал дэмжигдлээ.

Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Асуулт асуух гишүүд байхгүй байна. /алх цохив/

3.Төслийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсгийн “өртгийн” гэснийг “үйлдвэрлэлийн” гэж өөрчлөн, цаашид тохиолдол бүрт өөрчлөх.

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

62.5 хувиар санал дэмжигдлээ.

Хуулийн төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Асуулт асуух гишүүн байхгүй байна. /алх цохив/

4.Төслийн 4 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4 дүгээр зүйл.Хуулийн нэр томьёоны тодорхойлолт

4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томьёог доор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1.“хөдөө аж ахуйн үйлдвэрлэл” гэж хөдөө аж ахуйн газарт байгалийн болон биологийн нөөцөд тулгуурлан мал аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэл дагнан, эсхүл хослуулан эрхлэх үйл ажиллагааг;

4.1.2.“мал аж ахуйн үйлдвэрлэл” гэж мал, амьтныг өсгөн үржүүлж, тэдгээрээс гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг бэлтгэн нийлүүлэх, үйлдвэрлэх үйл ажиллагааг;

4.1.3.“тариалангийн үйлдвэрлэл” Тариалангийн тухай хуулийн 16.1-д заасныг;

4.1.4.“бэлчээрийн мал аж ахуй” гэж мал сүргийг бэлчээрт жилийн туршид улирлын хуваарьтайгаар идээшлүүлэн маллаж, ашиг шимийг нь хүртдэг, нүүдлийн өв соёлыг хадгалсан уламжлалт мал аж ахуйн үйлдвэрлэлийг;

4.1.5.“эрчимжсэн мал аж ахуй” гэж Тариалангийн тухай хуулийн 3.1.7-д заасныг;

4.1.6.“хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн” гэж хүнсний болон аж үйлдвэрийн зориулалтаар ургамал, мал, тэжээвэр амьтны аж ахуйгаас үйлдвэрлэсэн түүхий эд, бүтээгдэхүүнийг;

4.1.7.“агро-ойн аж ахуй” гэж ойжуулалтыг хөдөө аж ахуйн үйлдвэрлэлтэй зориудаар хослуулсан, нийгэм, эдийн засаг, байгаль орчны ашиг тустай аж ахуйн зохион байгуулалтыг;

4.1.8.“хөдөө аж ахуйн аялал жуулчлал” гэж мал аж ахуй, газар тариалан, уламжлалт нүүдлийн ахуйн хэв маяг, үндэсний соёл, өв уламжлалыг хадгалах, сурталчлан таниулах аялал жуулчлалын төрлийг;

4.1.9.“хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгч” гэж энэ хуулийн 4.1.1-д заасан үйл ажиллагааг эрхэлж, эдийн засгийн өгөөж хүртэж байгаа хувь хүн, хуулийн этгээдийг;

4.1.10.“тогтвортой хөдөө аж ахуй” гэж хүн, байгаль орчинд ээлтэй, нийгмийн хариуцлагатай, байгалийн нөөцийн зохистой ашиглалт, эдийн засгийн өгөөжтэй, урт хугацаанд үргэлжлэх, бүтээмжтэй хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг;

4.1.11.“хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн сүлжээ” гэж хөдөө аж ахуйн түүхий эд, бүтээгдэхүүн үйлдвэрлэх, бэлтгэн нийлүүлэх, анхан шатны боловсруулалт хийх, хадгалах, тээвэрлэх, борлуулах цогц үйл ажиллагааг.”

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

62.5 хувиар санал дэмжигдлээ.

Хуулийн төслийн 5 дугаар зүйлтэй холбогдуулан асуултаа асуух гишүүд нэрсээ өгнө үү? Асуулт асуух гишүүд байхгүй байна. /алх цохив/

5.Төслийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийн “хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн тогтвортой хөгжлийг хангах,” гэснийг хасах.

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

62.5 хувиар санал дэмжигдлээ.

6.Төслийн 5 дугаар зүйлийн 5.2.4 дэх заалтын “инноваци, дэвшилтэт шинэ технологийг” гэснийг “инновацыг” гэж өөрчлөх.

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

68.8 хувиар санал дэмжигдлээ.

7.Төслийн 5 дугаар зүйлийн 5.2.5 дахь заалтын “хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд” гэснийг, 5.2.6 дахь заалтын “хөдөө аж ахуйн хөдөлмөрийн үнэлэмж,” гэснийг, 5.2.7 дахь заалтын “түүхий эд” гэсний өмнөх “хөдөө аж ахуйн” гэснийг, 5.2.8 дахь заалтын “залгамж халааг тасралтгүй бэлтгэх тогтолцоог бэхжүүлэх” гэснийг тус тус хасах.

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

62.5 хувиар санал дэмжигдлээ.

8.Төслийн 5 дугаар зүйлийн 5.2.9 дэх заалтын “хувийн хэвшил,” гэснийг “хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан,” гэж өөрчлөх.

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

68.8 хувиар санал дэмжигдлээ.

Хуулийн төслийн 6 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Асуулт асуух гишүүд байхгүй байна. /алх цохив/

9.Төслийн 6 дугаар зүйлийн 6.1.2 дахь заалтын “тариалан” гэсний өмнө “газар” гэж, 6.3 дахь хэсгийн “тариалангийн” гэсний өмнө “газар” гэж тус тус нэмэх.

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

68.8 хувиар санал дэмжигдлээ.

10.Төслийн 6 дугаар зүйлийн 6.2.5, 6.2.6 дахь заалтыг тус тус хасах.

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

68.8 хувиар санал дэмжигдлээ.

11.Төслийн 6 дугаар зүйлийн 6.4, 6.5 дахь хэсгийг тус тус хасах.

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

56.3 хувиар санал дэмжигдлээ.

Хуулийн төслийн 7 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Асуулт асуух гишүүд байхгүй байна. /алх цохив/

12.Төслийн 7 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“7 дугаар зүйл.Хөдөө аж ахуйг төрөлжүүлэн хөгжүүлэх

7.1.Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын хүрээнд газар зүйн байршил, экологийн онцлог, дэд бүтцийн хөгжил, хүн амын нягтрал болон биологийн бусад нөөц, зах зээлийн эрэлтэд тулгуурлан төрөлжүүлэн хөгжүүлнэ.

7.2.Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг төрөлжүүлэн хөгжүүлэх тэргүүлэх чиглэлд бэлчээрийн болон эрчимжсэн мал аж ахуй, тэжээл үйлдвэрлэл, жимс, жимсгэнэ, хүнсний ногоо, үр тариа, хамгаалагдсан хөрсний тариалан, үржлийн аж ахуй, агро-ойн аж ахуйг хөгжүүлэх асуудлыг тусгайлан хамааруулна.

7.3.Хөдөө аж ахуйг төрөлжүүлэн хөгжүүлэх асуудлыг Хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тодорхойлж, орон нутгийн хөгжлийн бодлого, Засаг даргын мөрийн хөтөлбөрт тусган хэрэгжүүлнэ.

7.4.Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг хоршоо, кластерын зохион байгуулалтаар болон хөдөө аж ахуйн захиалгат бүтээгдэхүүн үйлдвэрлэлээр төрөлжүүлэн хөгжүүлж болно.”

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

68.8 хувиар санал дэмжигдлээ.

Хуулийн төслийн 8 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Ажлын хэсгээс гаргасан санал.

Сайнхүүгийн Ганбаатар гишүүний микрофоныг нээе.

С.Ганбаатар: Энэ хуулийг дэмжиж байгаа. Яг ний нуугүй хэлэхэд. Бас оройтож орж ирж байгаа.

Монгол орон хөдөө аж ахуйн орон. Тэгээд хөдөө аж ахуйн хууль тогтоомжуудыг шинэчлэх ёстой.

8 дугаар зүйл дээр гол юм нь энд байгаа юм. Өөрөөр хэлбэл хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд бүтээгдэхүүнийг төвлөрүүлэх, хадгалах, чанар хамгаалалт хийх, худалдан борлуулах төвийг аймаг, сумд байгуулна. Төр, хувийн хэвшлийн түншлэлээр хөгжүүлнэ гэж байгаа.

Тэгэхээр төр, хувийн хэвшлийн түншлэлээр хөгжүүлнэ гээд зүгээр тунхаг маягтай орж байгаа юу? Энэ хэрэгжүүлэх механизм нь юу байгаа вэ? Би энэ дээр тодруулж асуух гээд байгаа юм гэвэл энэ хамгийн энэ хуулийн амин сүнс нь энд л байгаа.

Одоо ерөөсөө өнөөдрийг хүртэл төр би бүхнээс мундаг, би бүхнээс ухаантай гээд л хамцуй шамлаж дайрсаар байгаад л бүх юмыг унагаад дууссан.

Одоо энэ хөдөө аж ахуй дээр, мал аж ахуй дээр, хөдөө аж ахуйн асуудал дээр төр, хувийн хэвшлийн түншлэлээр хөгжүүлнэ гэж байгаа. Энэ лоозон

болохгүй байх, хэрэгжүүлэх энэ механизм нь яг энэ хуулийн амин сүнс нь хаана байгаа вэ?

Тэгээд энэ дээр яаж хэлэлцээр хийх вэ? Тэр хэлэлцээр нь хэрэгжих ямар баталгаа байгаа вэ? Төр нь өнөөдөр зүгээр хүмүүсийг жагсааж байгаад гэрийнхээ гадаа тэгээд л ер нь хэн нь ахиухан шиг авлигал өгсөн байна гэдгээр дүгнэхгүйгээр яг тэр мэргэжлийн институцийн түвшинд хөгжлийн чадавхыг нь хангах гэсэн тийм боломж энэ дотор байгаа юу?

Өөрөөр хэлбэл салбар салбарын тариалангийн байна уу, хүнсний ногоо байна уу, сүү, мах, ноос ноолуур гэсэн тэр мэргэшсэн тэр холбоодуудын оролцоог, чадавхыг яаж нэмэгдүүлэх вэ? Тэдэнтэй яаж хэлэлцээр хийж шийдвэр гаргах вэ гэдэг механизмыг нь би тодруулж энэ дээрээс асууя.

Л.Мөнхбаясгалан: Ж.Бат-Эрдэнэ гишүүн хариулах уу?

Ж.Бат-Эрдэнэ: 8 дугаар зүйл хөдөө аж ахуйн түүхий эд, бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэлтийн тогтолцоо гээд.

Бид малаас гаралтай малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг тодорхой цэг дээр хүлээж аваад, бэлтгэн нийлүүлэлтийг нь хангаад, тэгээд хадгалах болон арчлах, давслах гээд бүтээгдэхүүнийг удаан хадгалахад нь зориулсан гэсэн ийм хэмжээний төв байх нь зүйтэй гэж үзэж байгаа шүү дээ.

Хуучин социализмын үед сум болгон дээр л байсан.

Өнөөдөр орон нутагт харахад энэ төв үнэхээр дутагдаад байгаа юм.

Хоёрдугаарт, таны санаа зовоод байгаа, энэ дээр бүр албаар энэ төвийг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хэмжээнд нь санхүүжилтээр шийдвэрлэнэ гэж бүр заалт болгож оруулж ирсэн юм. Энэ өөрөө баталгаа болж байгаа.

Төр, хувийн хэвшлийн түншлэлээр.

Магадгүй тодорхой хэмжээний орон нутгийн дэмжлэг байх байх. Гэхдээ одоо ерөөсөө орон нутаг өөрсдөө аваад явдаг ийм зүйлээс бид чинь татгалзаад байгаа шүү дээ. Бид хэд хэдийгээр энд ярьж байгаа ч гэсэн орон нутагт энэ үнэхээр санхүүжилтийн хүрээнд тэртээ тэргүй төсөв дээр мөнгө төгрөг байхгүй.

Хувийн хэвшлээр хийгдэнэ гэдгийг энд бүр заалт болгож шинээр оруулж өгч байгаа чинь өөрөө баталгаа болж өгч байгаа юм. Эндээ л бид найдаж байгаа юм.

Түүнээс биш төсвөөс хийгээд байдаг зүйл маань бүр харилцан адилгүй боллоо шүү дээ.

Өнөөдөр яг тэр хэмжээнд төсөв өөрөө хийгээд төр өөрөө аваад явдаг зүйлээс бид хаа сайгүй татгалзаад байгаа. Энэ бол хөдөө амьдрал дээр бодитой хэрэгжихээр болоод байгаа юм. Ер нь бол.

Яах вэ, төр, хувийн хэвшлийн хамтын санхүүжилтээр гэж байгаа юм л даа. Яг орон нутагт хэрвээ өнөөдөр бид ийм төвийг байгуулах ёстой гэдгийг орон нутагт бүгдээрээ мэдэж байгаа, аж ахуйн нэгжүүд бүгдээрээ мэдэж байгаа.

Бидний нэрлээд байгаа ченжүүд гэж байгаа шүү дээ. Эд нар л ер нь оронцоглоод яваад байгаа шүү дээ. Ерөнхийдөө.

Тэгэхээр бидний хүрээнд стандартыг нь тавьж өгье. Тодорхой хэмжээнд ийм хэмжээнд авч яв гэхээр хөрөнгө мөнгөний асуудлууд нь дутагдалтай байгаа.

Тэгэхээр ард талын заалт дээр дэмжлэг гэж оруулж ирж байгаа. Ямар нэгэн байдлаар хөдөө аж ахуйн дэмжлэгийг үзүүлнэ гэдэг. Тодорхой хэмжээний дэмжлэгүүд байх ёстой. Тэгээд орон нутгийн тодорхой хэмжээний бас хамтын санхүүжилтийн болоод бусад механизм байх нь зүйтэй юм л гэж харж байгаа.

Одоо яг өнөөдрийн байдлаар миний хувьд “Шинэ хөдөө” гээд хөтөлбөр хэрэгжүүлээд явсан.

Энэ 8 жилийн хугацаанд хэрэгжүүлээд явахад орон нутагт яг ийм төвийг байгуулъя гээд л яриад байгаа мөртлөө яг босож хүрч ирээд байгуулах аж ахуйн нэгж байхгүй. Тэд нарт нь санал болгоод л яваад байгаа юм.

— Яг ийм зүйл хийгээч ээ.

— Яг ийм байдалтайгаар цаашаагаа хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг хөгжүүлээч ээ.

— Нэг ийм хэлбэртэй байх юм шүү.

— Энэ бэлтгэн нийлүүлэлтийн тогтолцоогоо бид хангах ёстой –

-гээд байхад яг босоод өөрсдийнхөө хөрөнгөөр хийгээд өгөх боломж бололцоо гарахгүй байгаад байгаа байхгүй юу.

Л.Мөнхбаясгалан: Асуулт асууж дууслаа.

13.Төслийн 8 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“8 дугаар зүйл.Хөдөө аж ахуйн түүхий эд, бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэлтийн тогтолцоо

8.1.Хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг төвлөрүүлэх, хадгалах, чанар хамгаалалт хийх, худалдан борлуулах төвийг аймаг, суманд байгуулна.

8.2.Энэ хуулийн 8.1-д заасан төвийн үйл ажиллагааг төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлнэ.

8.3.Энэ хуулийн 8.1-д заасан төвд нийлүүлж, худалдан борлуулж байгаа түүхий эд, бүтээгдэхүүний талаарх мэдээлэл нь хөдөө аж ахуйн биржийн болон энэ хуулийн 10.1-д заасан цахим сантай холбогдсон байна.

8.4.Энэ хуулийн 8.1-д заасан төв нь түүхий эд, бүтээгдэхүүнийг худалдан авах, холбогдох стандарт, техникийн зохицуулалтын шаардлагын дагуу чанараар ангилах, шаардлагатай анхан шатны тордолт хийх, багцлах, савлах, шошголох, хадгалах, худалдан борлуулах үйл ажиллагааг хариуцан гүйцэтгэнэ.

8.5.Энэ хуулийн 8.1-д заасан төвийг байгуулах санхүүжилтийн эх үүсвэрийг улсын болон аймаг, сумын төсөв, хувийн хэвшлийн санхүүжилтээр /түншлэлээр/ шийдвэрлэнэ.”

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

56.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Хуулийн төслийн 9 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Ажлын хэсгээс гаргасан нэг санал байгаа. Асуулт асуух гишүүн алга байна. /алх цохив/

14.Төслийн 9 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“9 дүгээр зүйл.Хөдөө аж ахуйн түүхий эд, бүтээгдэхүүний чанарын үнэлгээ, баталгаажуулалт

9.1.Хөдөө аж ахуйн түүхий эд, бүтээгдэхүүний чанарыг холбогдох стандартын дагуу үнэлж, баталгаажуулна.

9.2.Аймаг бүр хөдөө аж ахуйн гаралтай хүнсний бус түүхий эд, бүтээгдэхүүний чанарыг шинжлэн судалдаг зориулалтын тоног төхөөрөмж, мэргэшсэн шинжээч бүхий лабораторитой байна.

9.3.Хөдөө аж ахуйн гаралтай хүнсний эрүүл ахуй, чанарын шинжилгээг холбогдох хуулиар зохицуулна.”

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

56.3 хувиар санал дэмжигдлээ.

Хуулийн төслийн 10 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Ажлын хэсгийн гаргасан санал нэг байгаа. Асуулт асуух гишүүн байхгүй байна. /алх цохив/

15.Төслийн 10 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“10 дугаар зүйл.Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн сүлжээний бүртгэл, мэдээлэл

10.1.Хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь хүнсний бүтээгдэхүүний, зөвшөөрлийн, мал аж ахуй, газар тариалангийн, малын генетик нөөц, мал, амьтан, ургамлын эрүүл мэндийн, түүхий эд, бүтээгдэхүүний гарал үүслийн, дотоодын болон олон улсын худалдаа, үйлчилгээний цахим сан (цаашид “цахим сан” гэх)-тай байна.”

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

56.3 хувиар санал дэмжигдлээ.

Хуулийн төслийн 11 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Ажлын хэсгээс санал гараагүй байна.

Хуулийн төслийн 12 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Ажлын хэсгээс гаргасан санал нэг байгаа. Асуулттай гишүүн байхгүй. /алх цохив/

16.Төслийн 12 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“12 дугаар зүйл.Тогтвортой хөдөө аж ахуйн төлөвлөлт

12.1.Тогтвортой хөдөө аж ахуйг хөгжүүлэх Хөгжлийн зорилтот хөтөлбөртэй байна.

12.2.Хөдөө аж ахуйн хөгжлийн зорилтот хөтөлбөрт дараах асуудлыг тусгана:

12.2.1.хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг төрөлжүүлэн хөгжүүлэх;

12.2.2.хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд шаардагдах мэргэшсэн хүний нөөцийн хэрэгцээг мэргэжил, мэргэшлийн түвшнээр тодорхойлж, хангах арга хэмжээ;

12.2.3.дотоодын хүнсний хангамж, экспортын бүтээгдэхүүний нийлүүлэлт, борлуулалт;

12.2.4.түүхий эд, бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэлт;

12.2.5.хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний экспортын зах зээлийг судалж, экспортын голлох бүтээгдэхүүн тус бүрээр бодлого, стратеги;

12.2.6.хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг ашигтай эрхлэх зах зээлийн болон нийгмийн таатай орчин бүрдүүлэлт.

12.3.Хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн энэ хуулийн 12.1-д заасан зорилтот хөтөлбөрийг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нийцүүлэн батлуулж, хэрэгжилтийг хангана.

12.4.Хөдөө аж ахуйн салбарт хэрэгжүүлж байгаа олон улсын төсөл, хөтөлбөрт энэ хуулийн 12.1-д заасан хөгжлийн зорилтот хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр тусгана.”

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

56.3 хувиар санал дэмжигдлээ.

Сайнхүүгийн Ганбаатар гишүүний микрофоныг өгье.

С.Ганбаатар: Энэ бас л миний их дэмжиж явдаг л зүйл дээ.

Хөдөө аж ахуйн судалгаа ба хөгжүүлэлт.

Монгол оронд “хөдөө аж ахуйн судалгаа, хөгжүүлэлт” улаан ноль байдаг.

Израилыг хөгжсөн гээд л яриад л байна. Израилыг Pentium III ч гэдэг юм уу, Dual-core гээд компьютер шинжлэх ухаан л гэж яриад байна.

Яг нарийн яривал Израилын хөгжлийн үндсийн 80 хувийг нь хөдөө аж ахуйдаа технологи инновац оруулдаг. Тэр банана байна уу. Тэр говьд яаж усыг бий болгох вэ, яаж усыг ашиглах вэ гэдэг.

Манайд энэ тал дээр их бага анхаардаг. Хөтөлбөрт тусгасан судалгаа хөгжүүлэлтийг гүйцэтгэхэд чиглэгдэнэ гэж байгаа. Энэ дээр тодорхой санхүүжилтийн эх үүсвэр, тодорхой механизм байгаа юу? Зүгээр лоозон болчихгүйгээр энэ яг бодитой хэрэгжихийн тулд уул уурхай гэж үндсэндээ хөдөө аж ахуйг будаа болгож орж ирж байгаа.

Энэ мэдээж давуу тал байлгүй яах вэ. Сургууль, цэцэрлэг, эмнэлэг бүгд л тэндээс санхүүжиж байгаа.

Хөдөө аж ахуй руу тэндээс оруулж байгаа санхүүжилтийн механизмыг тодорхой болгох тийм санал, санаачилга энэ хуулийн хүрээнд яригдсан уу? Тэрийг би тодруулж асууя даа.

Л.Мөнхбаясгалан: Ж.Бат-Эрдэнэ гишүүн хариулъя.

Ж.Бат-Эрдэнэ: Хуулийн төсөлд “хөдөө аж ахуйн судалгаа ба хөгжүүлэлт” гээд таны ярьж байгаа саналтай яг санал нэг оруулж ирж байгаа юм.

Өөрөөр хэлбэл яг хөдөө аж ахуйн хөгжүүлэлтийг стандартын дагуу олон улсын техник, технологи, ноу-хау юу байдаг юм тэр хэмжээнд нь хөгжүүлье. Тэгэхгүй бол бид чинь уламжлалт хөдөө аж ахуйгаар л ерөнхийдөө яваад байна шүү дээ.

Тэгэхээр ингэж оруулахын тулд хөдөө аж ахуйн судалгаа, хөгжүүлэлтийн тогтолцоо, дэвшилтэт технологи, инновацыг нэвтрүүлэх, оюуны өмчөөр хамгаалагдсан мэдлэгийг эргэлтэд оруулах гээд ийм заалтууд орж ирж байгаа.

Яг одоо санхүүжилтийг тэндээс гаргаж ирнэ ч гэдэг юм уу, улсын төсвөөс ч гэдэг юм уу, ийм зүйлийг тодорхойлж заагаагүй байгаа. Ямар ч байсан хөдөө аж ахуйн тухай хуульдаа –

- хөгжүүлэлт зайлшгүй байх ёстой,
- судалгаатай байх ёстой –

-гэсэн ийм зүйлийг л оруулж байгаа юм.

Бид ажлын хэсэг дээр Хөдөө аж ахуйн яамны мэргэжилтнүүдтэй нэлээн суусан. Бодлогын хүрээнд цаашдаа яг энэ хүрээнд авч явъя. Өөрөөр хэлбэл судалгааны байгууллагуудаа хажуудаа татъя гээд дараагийнхаа заалтаар орж ирж байгаа.

Энэ хэдэн судалгааны байгууллагууд чинь бүгдээрээ салаад тараад явсан шүү дээ. Зарим нь Боловсролын яам руу, зарим нь академи руу салсан.

Тэд нарыгаа хажуудаа байлгаж байгаад –

- тэндээсээ бодлого гарч ирдэг,
- тэндээсээ судалгаа гаргадаг,
- тэндээсээ тогтолцоогоо өөрчилдөг,
- түүндээ зориулчихсан бодлогыг –

-Хөдөө аж ахуйн яамнаасаа гаргаж байя гэсэн ийм бодлого л орж ирж байгаа.

Тэгэхээр мэдээж санхүүжилтийн асуудал чухал. Ингээд цаашаа тодорхой хэмжээнд шийдэгдээд явах байх.

Ер нь “хөдөө аж ахуйн дэмжлэг” гэдэг том заалтууд орж ирж байгаа шүү дээ. Тэр дэмжлэгийнхээ хүрээнд санхүүжилтийн болоод бусад дэмжлэгүүд байна гэдэг ийм заалт ороод ирж байгаа юм.

Л.Мөнхбаясгалан: Тодруулах уу? Болсон уу?

17.Төслийн 13 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“13 дугаар зүйл.Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн газар

13.1.Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэх баталгааг дэмжих зорилгоор төрөөс холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчид газрыг ашиглах, эзэмших нөхцөлийг бүрдүүлнэ.

13.2.Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах уст цэг, худгийн хоорондох зайг усны нөөц, уст цэгийн хайгуулын дүн, бүс нутгийн газар зүйн онцлогт үндэслэн аймаг, нийслэлийн Засаг дарга тогтооно.

13.3.Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн хэрэгцээний усны нөөц, уст цэгийн хайгуул, судалгаа хийх, хэрэгжүүлэхтэй холбогдох харилцааг Усны тухай хуулиар зохицуулна.

13.4.Хөдөө аж ахуйн газрын ангиллыг өөрчлөх, ангилал шилжүүлэх тохиолдолд Газрын тухай хуулийн 23.2.9-д заасныг баримтлах бөгөөд улсын хөгжлийн бодлогын зайлшгүй шаардлагатайгаас бусад тохиолдолд хөдөө аж ахуйн газрыг нэгдмэл сангийн өөр ангилалд шилжүүлэхгүй.”

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

56.3 хувиар санал дэмжигдлээ.

18.Төслийн “Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн хүний нөөц” гэсэн 14 дүгээр зүйлийг хасах.

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

62.5 хувиар санал дэмжигдлээ.

Хуулийн төслийн 15 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Ажлын хэсгээс гаргасан санал нэг. Асуулт асуух гишүүн байхгүй байна. /алх цохив/

19.Төслийн 15 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“15 дугаар зүйл.Хөдөө аж ахуйн судалгаа ба хөгжүүлэлт

15.1.Хөдөө аж ахуйн судалгаа ба хөгжүүлэлтийн тогтолцоо нь дэвшилтэт технологи, инновацыг нэвтрүүлэх, оюуны өмчөөр хамгаалагдсан мэдлэгийг эргэлтэд оруулах, зах зээлд гаргах, энэ хуулийн 12.1-д заасан зорилтот хөтөлбөрт тусгасан судалгаа, хөгжүүлэлтийг гүйцэтгэхэд чиглэгдэнэ.

15.2.Хөдөө аж ахуйн салбарын шинжлэх ухаан, технологи, инновацын судалгааны үр дүнг нэвтрүүлэх, зөвлөх үйлчилгээ үзүүлэх, сургалт, сурталчилгаа зохион байгуулах чиг үүрэгтэй төрийн үйлчилгээний байгууллага хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэд ажиллана.”

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

62.5 хувиар санал дэмжигдлээ.

Хуулийн төслийн 16 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Ажлын хэсгээс гаргасан санал нэг байгаа. Асуулт асуух гишүүн байхгүй байна. /алх цохив/

20.Төслийн 16 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

**“16 дугаар зүйл.Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн эрсдэл,
түүнээс урьдчилан сэргийлэх**

16.1.Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээний нэгдсэн удирдлагыг хэрэгжүүлнэ.

16.2.Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн эрсдэлийг доор дурдсан ангиллын дагуу үнэлэх, урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

16.2.1.байгаль орчны;

16.2.2.эдийн засгийн;

16.2.3.нийгмийн.

16.3.Энэ хуулийн 16.2.1-д заасан нөлөөллийн эрсдэлд бэлчээрийн болон тариалангийн газрын доройтол, усны хомсдол, генетик нөөцийн төлөв, уур амьсгалын өөрчлөлт, хүлэмжийн хийн ялгаруулалт, хог хаягдлын менежмент хамаарна.

16.4.Энэ хуулийн 16.2.2-т заасан нөлөөллийн эрсдэлд хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн эрэлт, нийлүүлэлтийн тэнцвэр, бүтээмж, өрсөлдөх чадвар, эдийн засгийн өгөөж, түүхий эд, бүтээгдэхүүний үнийн хэлбэлзэл, санхүүжилтийн хүртээмж, төрийн дэмжлэгийн үр дүн хамаарна.

16.5.Энэ хуулийн 16.2.3-т заасан нөлөөллийн эрсдэлд хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчийн тогтвортой ажлын байр, ажиллах орчны аюулгүй байдал, нийгмийн баталгааны өөрчлөлтөд дасан зохицох чадамж хамаарна.

16.6.Хөдөө аж ахуйн салбарын өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах, байгалийн эрсдэлээс сэргийлэх, хамгаалах арга хэмжээг Засгийн газар болон орон нутгийн засаг захиргаа авч, хэрэгжилтэд хяналт тавина.”

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

Ж.Бат-Эрдэнэ гишүүний микрофоныг өгье.

Ж.Бат-Эрдэнэ: Энэ хамгаалах арга хэмжээг Засгийн газар “орон нутгийн засаг захиргаа” гээд нэг үг, үсэг оруулъя гэж байсан. Тэр хаягдчихсан юм шиг байгаа юм.

Бид өчигдөр ажлын хэсэг дээр ярьсан шүү дээ. Засгийн газар, тэгээд орон нутгийн засаг захиргаа гэсэн байх. Алив, томъёолол чинь байна уу?

Сэргийлэх, хамгаалах арга хэмжээг.

Л.Мөнхбаясгалан: 16.6.

Ж.Бат-Эрдэнэ: 16.6.хөдөө аж ахуйн салбарын өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах, байгалийн эрсдэлээс сэргийлэх, хамгаалах арга хэмжээг Засгийн газар болон орон нутгийн засаг захиргаа...

Л.Мөнхбаясгалан: Засгийн газар болон орон нутгийн...

Ж.Бат-Эрдэнэ: ...засаг захиргаа арга хэмжээг авч хэрэгжүүлж хэрэгжилтэд хяналт тавина. Энэ чинь дан Засгийн газар болчхож байгаа байхгүй юу. Орон нутгийн хяналт чинь байх гээд ёстой гэж өчигдөр ажлын хэсэг дээр бид ярьсан. Тийм ээ.

Л.Мөнхбаясгалан: 16.6-г дахиж унших уу?

Ж.Бат-Эрдэнэ: Тэгье.

Л.Мөнхбаясгалан: Томьёоллыг нь. Тийм ээ. Хөдөө аж ахуйн салбарын өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах, байгалийн эрсдэлээс сэргийлэх, хамгаалах арга хэмжээг Засгийн газар болон орон нутгийн засаг захиргаа арга хэмжээг авч хэрэгжүүлэн, хэрэгжилтэд хяналт тавина. Зөв үү?

Санал хураалт. /алх цохив/

62.5 хувиар санал дэмжигдлээ.

Хуулийн төслийн 17 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Ажлын хэсгээс санал гараагүй байна.

17. Одоо 18.

Хуулийн төслийн 18 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Ажлын хэсгээс гаргасан нэг санал байна.

Сайнхүүгийн Ганбаатар гишүүний микрофоныг нээе.

С.Ганбаатар: Хэн нэгэн сайд хармаанаасаа мөнгө гаргаж өгөхгүй шүү дээ. Гэрээс нь юу ч гарахгүй. Энэ бол Монголын ард түмний татварын мөнгө гарах гэж байгаа.

Тэгэхээр энэ дээр “хөдөө аж ахуйн дотоодын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, импортыг орлох болон экспортын баримжаатай түүхий эд бүтээгдэхүүн үйлдвэрлэх бодлогын хүрээнд төрөөс дараах дэмжлэг үзүүлж болно” гэж үг яагаад байдаг юм бол? Болно, болохгүй гэхлээр энэ хуулийн хэрэг байгаа ч юм уу, үгүй ч юм уу. “Үзүүлнэ” гэмээр л байх юм. Нэгдүгээрт, миний асуулт.

Хоёрдугаарт, шууд болон шууд бус татаас, тариф болон тарифын бус зохицуулалт гээд. Ингээд “бусад” гээд юм явж байна.

Энэ 18.2 дахь зүйл дээр нь бас нэг юм байгаа юм. Юу гэвэл энэ ер нь зохистой дадал нэвтрүүлсэн, баталгаажуулсан стандарт, техникийн

зохицуулалтын шаардлага хангасан, баталгаажуулсан, чанарын хамаарсан хүний тогтолцоог нэвтрүүлсэн гээд 6 зүйл байна.

Энэ болгоныг нэг улс төрчдөөр тавиулсан нэг дарга, нэг том дарга шийдэх үү? Үүнийг хэн тодорхойлох вэ? Үүнийг би тодруулмаар байна.

Тэгээд гурав дахь асуулт. Дараа нь гомдол гарна шүү дээ. Яг шударгаар хийгээд байхад л тэгээд л идчихсэн, уучихсан, мафидчихсан гээд л яриад байхгүй. Тэр гомдол гаргахад магадлалтай буюу мэргэжлийн холбоодын төлөөллийн байгууллагуудаас энд бас оролцоог нь хангасан тийм механизм байж болохгүй юу гэсэн ийм гурван асуултыг би тодруулъя.

Л.Мөнхбаясгалан: Ж.Бат-Эрдэнэ гишүүн хариулъя.

Ж.Бат-Эрдэнэ: Энэ ажлын хэсгийн санал дээр би таныг зарчмын зөрүүтэй санал оруулж ирж байна гэж харж байна.

Ер нь “дэмжлэг үзүүлнэ”, “дэмжлэг үзүүлж болно” гэдэг дээр ажлын хэсэг нэлээн маргаж байгаад тэгээд “үзүүлж болно” гэдэг дээр нь тавьсан юм.

Яагаад гэхээр тодорхой дэмжлэгүүдийг хөдөө аж ахуйн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага буюу бодлого Засгийн газар, хөдөө аж ахуйгаас гарна шүү дээ.

Тэгэхээр энэ болгон дээр дэмжлэгүүдийг өнөөдөр Засгийн газраас зэрэг бүгдийг нь явуулж чадахгүй байна шүү дээ.

Тэгэхээр тодорхой хэмжээний үе шаттай ч байдаг юм уу, тодорхой хэмжээний цаг хугацаатай ч байдаг юм уу, энэ асуудал дээр нь ийм юм гарлаа. Одоо жишээ нь сая хүнсний асуудалтай холбоотойгоор, хүнсний аюулгүй байдалтай холбоотой дэмжлэгүүд явлаа шүү дээ. Энэ их үр өгөөжтэй болсон. Тийм үү? Үр өгөөжөө өгсөн.

Энэ мэтчилэн үе шаттайгаар явагдах болохоор “болно” гэж л тавья. Ер нь дэмжлэг гээд нэгэнт хуульдаа заагаад өгч байгаа юм чинь ийм дэмжлэгүүд байж болно. Үүнийг тодорхой хэмжээнд Хөдөө аж ахуйн яам маань бодлогоо эндээ зангидаад цаашаа явна гэдэг байдлаар л гаргаад ирж байгаа юм.

Шууд “үзүүлнэ” гэхээр аягүй том бодлогын хүрээнд магадгүй хэрэгжих явц нь яах юм болов уу гэж бодоод л ингэж оруулсан байгаа юм.

Хоёрдугаарт, “зохистой дадал нэвтрүүлсэн”, “баталгаажуулсан байна” гэдэг дээр ерөнхийдөө Хөдөө аж ахуйн яамнаас бодлогууд гараад явж байгаа юм байна. Бид яг энэ асуудал дээр хэн нэгэн төрийн албан хаагч тэнд хүнд суртал

гаргаад, үүнийг нь болно, үүнийг нь болохгүй гээд, үүнийг нь баталгаажуулаагүй байна ч гэдэг юм уу, ийм хүнд суртал гаргаад, нөгөөдүүлийг чинь хаадаг, боодог тийм зүйл гарах вий гэдэг дээр бид бас нэлээн болгоомжилж Хөдөө аж ахуйн яамныхантай ярьсан. Орон нутаг дээр энэ бодлогоо хэрэгжүүлдэг байя.

Энд өөр нэг заалт орсон нь төрийн захиргааны төв байгууллага буюу хөдөө аж ахуйн асуудал гаргасан сайд болон Засгийн газраас тодорхой бодлогыг орон нутаг хүртэл хэрэгжүүлэхээр бүр бодлого зааж өгч байгаа юм. Бодлого зааж өгч байгаа юм.

Тэгээд үүнийхээ дагуу тодорхой бодлого, шаардлагуудаа аваад явчихъя. Өнөөдрийн хувьд жишээ нь “зохистой дадал” гэдэг бол тэртээ тэргүй хөдөө аж ахуй дээр бодлогоо нэвтрүүлээд явж байгаа гэж байгаа шүү дээ. Нэвтрүүлээд явж байгаа.

Гурав дахь нь юу байлаа? Ер нь мэргэжлийн холбоодын асуудал дээр чинь бид нэлээн гүнзгий хуульд нь заагаад өгчхөөд байгаа шүү дээ.

- Хоорондоо зохицдог байх;
- Хоорондоо ярьдаг байх;
- Тодорхой гэрээ байгуулдаг байх.

Л.Мөнхбаясгалан: Сайнхүүгийн Ганбаатар гишүүн тодруулъя.

С.Ганбаатар: Гишүүний хэлсэн дээр би санал нэг байна. Яг тэрийгээ л оруулмаар байна.

“Төрөөс дараах дэмжлэг үзүүлж болно” гэхийн оронд “үе шаттайгаар дараах дэмжлэгийг үзүүлнэ” гэвэл амар. Би тэр саналыг дэмжиж байгаагаа илэрхийлье.

Хоёрдугаарт, жирийн хөдөлмөр хийж байгаа хүмүүс, бизнес эрхлэгчдийн татварын мөнгийг тэдний ямар ч оролцоогүйгээр шийдвэр дандаа гардаг нь Монголын төрийн ганцхан эмгэнэл нь. Ерөөсөө онцгой ганц эмгэнэл нь. Дарга л шийдэх дуртай.

Тэгэхээр миний протоколд үлдээх гээд байгаа юм нь хөдөө аж ахуйн салбарт явж байгаа энэ олон мэргэжлийн холбоод, мэргэжлийн төлөөллийн байгууллагуудыг оролцоог хангахыг анхаарах ёстой шүү гэдгийг би протоколд тэмдэглэж үлдээе.

Л.Мөнхбаясгалан: 18 дугаар зүйл хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн дэмжлэг.

21.Төслийн 18 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“18 дугаар зүйл.Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн дэмжлэг

18.1.Хөдөө аж ахуйн дотоодын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, импортыг орлох болон экспортын баримжаатай түүхий эд, бүтээгдэхүүн үйлдвэрлэх бодлогын хүрээнд төрөөс дараах дэмжлэг үзүүлж болно:

- 18.1.1.шууд болон шууд бус татаас;
- 18.1.2.тарифын болон тарифын бус зохицуулалт;
- 18.1.3.хөнгөлөлттэй зээл, зээлийн хүүгийн хөнгөлөлт;
- 18.1.4.бусад.

18.2.Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн дэмжлэг үзүүлэх үйлдвэрлэлийн сүлжээний оролцогч нь дараах шаардлагыг хангасан байна:

- 18.2.1.зохистой дадал нэвтрүүлсэн, баталгаажуулсан;
- 18.2.2.стандарт, техникийн зохицуулалтын шаардлага хангасан, баталгаажуулсан;
- 18.2.3.чанараас хамаарсан үнийн тогтолцоог нэвтрүүлсэн;
- 18.2.4.үйлдвэрлэлийн бүтээмжийг нэмэгдүүлсэн байх;
- 18.2.5.импортыг орлох, экспортын баримжаатай үйлдвэрлэл байх;
- 18.2.6.нэмүү өртөг шингээсэн байх.
- 18.2.7.тухайн салбарын мэргэжлийн холбоодын саналыг авч, зөвшилцөн байх.” найруулах

Санал гаргасан ажлын хэсэг. Шууд зарчмын зөрүүтэй саналаа хамт хураачих юм уу? Тийм ээ.

Сайнхүүгийн Ганбаатар гишүүний микрофоныг нээе.

С.Ганбаатар: 18.2.7-д шинээр заалт оруулаад. Түүн дээр энэхүү үйлдвэрлэлийн сүлжээний оролцогч дараах шаардлагыг хангасан байна гэдэг.

Энэхүү шаардлагыг тодорхойлохдоо “тухайн салбарын, тухайн мэргэжлийн холбоодын байр суурьтай зөвшилцсөн байна” гэдэг ийм саналыг оруулъя.

Л.Мөнхбаясгалан: Мэргэжлийн холбоодоос санал авч зөвшилцсөн байна байна гэдгийг нэмээд санал хураая. Санал хураалт. /алх цохив/

56.3 хувиар санал дэмжигдлээ.

Хуулийн төслийн 19 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Ажлын хэсгээс гаргасан санал нэг байгаа. Асуулт асуух гишүүн байхгүй байна. /алх цохив/

22.Төслийн 19 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“19 дүгээр зүйл.Хөдөө аж ахуйн салбар дахь төрийн удирдлага, зохицуулалт

19.1.Хөдөө аж ахуйн салбарын төрийн бодлого нь төвлөрсөн байх бөгөөд улсын хэмжээнд хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэлд хүнс, хөдөө аж ахуйн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, сум, дүүрэгт хөдөө аж ахуйн тасаг болон бусад харьяа байгууллагаас бүрдэнэ.

19.2.Хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний эрхлэх асуудлын хүрээнд мал, таримал ургамлын генетик нөөц, ургамлын болон мал, амьтны эрүүл мэнд, гений сан, малын эм үйлдвэрлэл, лаборатори, аймаг дундын отрын бэлчээр, шинжлэх ухаан, инновац, судалгаа, шинжилгээ, нэвтрүүлэлт хариуцсан төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний байгууллага, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд тус тус ажиллана.

19.3.Аймаг, нийслэлийн хүнс, хөдөө аж ахуйн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, хөдөө аж ахуйн тасгийн бүтцийг Засгийн газраас тогтоосон орон тооны хязгаарт багтаан хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

19.4.Энэ хуулийн 19.2, 19.3-т заасан байгууллага нь энэ хуульд болон холбогдох бусад хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлнэ.”

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

56.3 хувиар санал дэмжигдлээ.

Хуулийн төслийн 20 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Ажлын хэсгээс гаргасан санал нэг байгаа. Асуулт асуух гишүүн байхгүй байна. /алх цохив/

23.Төслийн 20 дугаар зүйлийг хасах.

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

56.3 хувиар санал дэмжигдлээ.

Хуулийн төслийн 21 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Ажлын хэсгээс санал гаргаагүй байна.

Хуулийн төслийн 22 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Ажлын хэсгээс гаргасан 3 санал байгаа.

С.Одонтуяа гишүүний микрофоныг нээе.

С.Одонтуяа: Тэгэхээр энэ хууль дээр дэд хэсэгт нь. Ажлын хэсгийн саналуудыг хэлэлцэх үед дэд хэсгийнхнээс, Байгаль орчны яамнаас хүмүүс ажилласан уу? Мэргэжилтнүүд ажилласан уу? Тийм ээ. Тэрийг л асуух гэсэн юм.

Л.Мөнхбаясгалан: Хаана яваа билээ? 22. Хуулийн төслийн 22 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт гишүүд асуулт асууж дууслаа. /алх цохив/

Ажлын хэсгээс гаргасан санал 3 байгаа.

24.Төслийн 22 дугаар зүйлийн хуулийг дагаж мөрдөх хугацааг “2027 оны 01 дүгээр сарын 01” гэж өөрчлөх.

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

50 хувь уначихлаа даа.

С.Одонтуяа гишүүний микрофоныг нээе.

С.Одонтуяа: Уучлаарай. Би уг нь дарсан юм. Төхөөрөмж буруу гарлаа. Саналыг хүчингүй болгох санал хурааж өгнө үү. Уучлаарай.

Л.Мөнхбаясгалан: С.Одонтуяа гишүүний гаргасан горимын саналаар саяын санал хураалтыг хүчингүй болгоё гэдгээр санал хураая. /алх цохив/

56.3 хувиар горимын санал дэмжигдлээ.

Төслийн 22 дугаар зүйлийн хуулийг дагаж мөрдөх хугацааг “2027 оны 01 дүгээр сарын 01” гэж өөрчлөх.

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

56.3 хувиар санал дэмжигдлээ.

25.Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах /6 дугаар зүйлийн 6.5 дахь хэсэгт “6.5.9.хөдөө аж ахуйн зорилтот хөтөлбөр.” гэсэн заалт нэмэх”/

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

56.3 хувиар санал дэмжигдлээ.

26.Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн нэр томъёог жигдлэх, зүйл, хэсэг, заалтын дугаарыг нийцүүлж өөрчлөх, бүтэц найруулга, хууль зүйн техникийн засварыг хийх.

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

56.3 хувиар санал дэмжигдлээ.

Хөдөө аж ахуйн тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Одоо Хөдөө аж ахуйн хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулъя.

Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Ажлын хэсгээс санал гаргаагүй байна.

Асуулт асуух гишүүн байхгүй байна. /алх цохив/

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Ажлын хэсгээс санал гаргаагүй байна. Байхгүй байна.

Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулъя.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Ажлын хэсгээс санал гаргаагүй байна.

Асуулт асуух гишүүн байхгүй. /алх цохив/

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү?

Ажлын хэсгээс санал гаргаагүй байна.

Асуулт асуух гишүүн байхгүй байна. /алх цохив/

Мал амьтны эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулъя.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Ажлын хэсгээс санал гаргаагүй байна.

Асуулт асуух гишүүн байхгүй. /алх цохив/

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү?

Ажлын хэсгээс санал гаргаагүй.

Асуулт асуух гишүүн байхгүй. /алх цохив/

Энэ асуудлыг хэлэлцэж дууслаа. /алх цохив/

Хөдөө аж ахуйн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаар Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын дэд дарга Ж.Бат-Эрдэнэ чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулна.

**Хоёр.Уур амьсгалын өөрчлөлтийн тухай
хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл
/Засгийн газар 2026 оны 05 сарын 21-ний өдөр өргөн мэдүүлсэн,
хэлэлцэх эсэх/**

Дараагийн асуудалдаа оръё. Ганцхан асуудал байгаа.

Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг хэлэлцүүлъя.

С.Амарсайхан сайд орж ирсэн юм уу. Хууль санаачлагчийн танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд С.С.Амарсайхан танилцуулна.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хүрэлцэн ирсэн ажлын хэсгийг танилцуулъя.

Эдийн засаг, хөгжлийн яам.

Б.Мөнх-Эрдэнэ Хөрөнгө оруулалтын бодлогын газрын дарга, Сангийн яам.
Б.Амарбаясгалан Санхүүгийн бодлогын газрын Санхүүгийн зах зээл, олон улсын хамтын ажиллагааны хэлтсийн дарга. Ирсэн байна.

Б.Номин Санхүүгийн бодлогын газрын Санхүүгийн зах зээл, олон улсын хамтын ажиллагааны ахлах мэргэжилтэн. Ирсэн байна.

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам.

Ш.Батбаяр Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч. Ирсэн байна.

н.Онон Байгаль орчин уур амьсгалын өөрчлөлтийн сайдын зөвлөх. Алга байна.

Б.Бат-Өлзий Бодлого, төлөвлөлтийн газрын дарга. Ирсэн байна.

Л.Мөнхзул Төрийн захиргааны удирдлагын газрын Хуулийн хэлтсийн дарга. Алга байна.

А.Нарангарав Бодлого, төлөвлөлтийн газрын ахлах шинжээч. Ирсэн байна.

Б.Номун Нэгдсэн Үндэстний Байгууллагын хөгжлийн хөтөлбөрийн хамтран хэрэгжүүлж буй Нүүрстөрөгчийн зах зээлийн бэлэн байдлыг бэхжүүлэх төслийн хуулийн зөвлөх. Ирсэн байна.

Хууль санаачлагчийн танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Хууль зүй, дотоод хэргийн сайд С.Амарсайхан танилцуулна.

С.Амарсайхан сайдын микрофоныг нээе.

С.Амарсайхан: Эрхэм Байнгын хорооны дарга, Байнгын хорооны гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас уур амьсгалын өөрчлөлтийн тухай хуулийн төслийг боловсруулан Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн.

Монгол Улсын уур амьсгалын өөрчлөлтөд хамгийн эмзэг орны нэг болоод байгаа бөгөөд сүүлийн 80 гаруй жилийн хугацаанд манай орны агаарын дундаж температур 2.5 хэмээр нэмэгдэж, ган, зуд, үер, шороо шуурга зэрэг гамшигт үзэгдлийн давтамж эрчим эрс өсөж байна.

Зөвхөн 2023-2024 оны зудын улмаас 9.1 сая толгой мал хорогдож, эдийн засагт 2.8 их наяд төгрөгийн хохирол учирсан нь уур амьсгалын өөрчлөлт байгаль орчны төдийгүй эдийн засаг, хүн амын амьжиргаа, үндэсний аюулгүй байдлын асуудал болсныг харуулж байна.

Монгол Улс Нэгдсэн Үндэстний Байгууллагын уур амьсгалын өөрчлөлтийн суурь конвенц болон Парисын хэлэлцээрийн хүрээнд олон улсын өмнө хүлээсэн үүргээ хэрэгжүүлэх үндэсний тодорхойлсон хувь нэмрийн зорилтоо хангах, ногоон шилжилтийг эрчимжүүлэх шаардлагатай гэж үзэж байгаа.

Гэвч өнөөг хүртэл уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой харилцааг салангид бодлого, салбарын хуулиудаар зохицуулж ирсэн бөгөөд нэгдсэн суурь эрх зүйн орчин дутмаг байна.

Иймд энэхүү хуулийн төсөл нь уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох, даван туулах бодлого, арга хэмжээг нэгдсэн тогтолцоонд оруулах, хүлэмжийн хийн хэмжилт, тайлагнал, баталгаажуулалтын тогтолцоог бүрдүүлэх, ногоон санхүүжилт болон нүүрстөрөгчийн зах зээлийн эрх зүйн орчныг бий болгоход чиглэж байгаа.

Түүнчлэн Монгол Улс 2026 онд Нэгдсэн Үндэстний Байгууллагын Цөлжилттэй тэмцэх тухай конвенцын талуудын 17 дугаар хурал буюу COP17 эх эх орондоо зохион байгуулах гэж буй энэ цаг үед уур амьсгал, цөлжилт, газрын доройтол, тогтвортой хөгжлийн асуудлаарх үндэсний манлайллаа бэхжүүлэх, олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлэх, ногоон хөрөнгө оруулалт татах эрх зүйн суурийг бүрдүүлэх стратегийн ач холбогдолтой юм.

Хуулийн төсөл батлагдсанаар уур амьсгалын өөрчлөлтийн засаглал, салбар дундын зохицуулалт сайжирч, олон улсын санхүүжилт болон хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт нэмэгдэх, карбон зах зээлийн эрх зүйн орчин бүрдэх, орон нутгийн дасан зохицох чадавх бэхжих, урт хугацааны тогтвортой хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх суурь нөхцөл бүрдэнэ.

Иймд Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэхийг дэмжиж өгөхийг байнгын хорооны гишүүд Та бүхнээс хүсье.

Л.Мөнхбаясгалан: С.Амарсайхан сайдад баярлалаа.

Хууль санаачлагчийн танилцуулгатай холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу?

Сайнхүүгийн Ганбаатар гишүүний микрофоныг нээе.

С.Ганбаатар: Энэ хуулийг дэмжиж байгаа. Дэмжихээс өөр аргагүй.

Монгол орон Германы том эрдэмтдийн судалгаагаар гарсан шүү дээ.

Хэдхэн жилийн дараа хүн амьдрах аргагүй газар болох нь байна шүү гэдэг дүгнэлтүүд гарсан байгаа. Энэ дээр үндэсний зохицуулагч байгууллага гээд хуудас 11-д бий болох юм байна. Өөр арга байхгүй. Байгаль орчны энэ чиг үүрэг бол бүр гол зохицуулалттай гол чиг үүрэг.

Ер нь бид байгаль орчноо л дээрэмдэж энэ 30 жил бизнес нэртэй л амьдарч байгаа улсууд шүү дээ.

Тэгэхээр энэ байгууллагын үр дүн яг яаж гарах вэ гэдэг дээр надад их тодорхой зүйлүүдийг хэлээд өгөөч.

Хоёрдугаарт, хуудас 20-д төслийн 23.4-д 4 төрлийн тодорхойлолтыг авах юм байна.

Энэ дээр тодорхой хэмжээгээр судалгаа хийсэн үү? 23.4-ийг хэлж байгаа юм шүү. 4 төрлийн тодорхойлолтыг авна.

Түүн дээр тодорхой судалгаа хийсэн үү? Энэ бэрхшээлгүйгээр үр дүнтэй байх судалгааны үр дүнг надад нэг танилцуулаач.

Дараагийн асуулт, хуудас 22-т байгаа. Төслийн 25-д нь газартай холбоотой карбон кредитийн зохицуулалтыг бий болгоно гэж байгаа.

Бид ч бараг сүүлийн 20-иод жил carbon credit trading л яриад л байдаг, яриад л байдаг. Болохгүй байгаа. Яг энэ 25 дугаар заалт үр дүн гаргана гэдэг ялгаа нь юу вэ?

Их Хурал руу орохоос өмнө зүгээр зөвлөгөө өгчихье.

Төслийн 31.3-ыг та нар нэг хараадхаарай. Тэнд заасан 22.7 гэсэн заалтыг би хайгаад олоогүй шүү. Энэ бичиглэлийн алдаа байж магадгүй. Эсвэл надад хэвлэж өгсөн нь бас алдсан байж болно. Тэрийг тодруулж хэлээрэй.

Тэгээд би, товчхондоо хэлэхэд ийм хууль орж ирж байгаа бол үнэхээр цаг үеэ олсон. Яаралтай орж оруулж ирэхгүй л бол манай Монгол оронд 1990 оноос хойш хүлэмжийн хий 82.1 хувь нэмэгдсэний 44.7 хувь нь эрчим хүчний салбараас, үйлдвэрлэл хог хаягдлаас үүдэлтэй гэж байгаа шүү дээ.

Энэ дээр төрийн зохицуулалт хийхээс өөр аргагүй байдал руу тулсан байгаа. Тэгээд үүнийг дэмжиж байгаа. Тэгээд саяын 4 асуултад би бас хариулт авъя.

Л.Мөнхбаясгалан: Индрийн микрофоныг нээе.

Ш.Батбаяр: Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ш.Батбаяр

С.Ганбаатар гишүүний асуултад хариулъя.

Үндэсний зохицуулагч байгууллагын гаргах хүн үр дүн юу вэ гэвэл зах зээлийн зохицуулалтыг нэгдүгээрт хийнэ.

Шинээр төсөл хэрэгжүүлэх байгууллага биш одоо байгаа манай Цаг уур, орчны шинжилгээний газар энэ үйл, бүтцийг авч явах юм. Ингэснээр төрд ямар нэгэн төсвийн дарамт болон шинээр орон тоо үүсэхгүй байгаа юм.

Мөн энэ байгууллага маань уур амьсгалын өөрчлөлтийн бодлого тайлагнал, карбон зах зээл, санхүүжилт, олон улсын үүргийн хэрэгжилтийг нэгтгэн уялдуулах чиг үүрэгтэй байх юм.

- Үр дүнд нь хүлэмжийн хийн тайлагналын чанар сайжирна.
- Үндэсний тодорхойлсон хувь нийгмийн зорилтын хэрэгжилт хангагдана.

Олон улсын санхүүжилт болон карбон зах зээлийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, салбар хоорондын уялдаа холбоог хангах үүрэг бүхий байгууллага байх юм.

Манай Цаг уур, орчны шинжилгээний газар дээр уур амьсгалын өөрчлөлт, цөлжилттэй холбоотой бүхий л тандан судалгааны ажлууд хийгддэг учраас энэ байгууллагыг бид сонгож хуульдаа зааж өгөхөөр оруулсан байгаа юм.

Хоёрдугаар асуулт нь, 4 төрлийн тодорхойлолт гэж байгаа.

- Уур амьсгалын өөрчлөлтийн суурь судалгаа;
- уур амьсгалын өөрчлөлтийн эрсдэлийн үнэлгээ;
- Эмзэг байдлын үнэлгээ;
- Гарз хохирлын үнэлгээ –

-гээд үнэлгээнүүдийг хийхээр байгаа.

Мөн чөлөөт зах зээл дээр орж ирж байгаа тоглогчдод “татгалзах зүйлгүй” гэсэн үг буюу NDC (Nationally Determined Contribution) дээр маань үндэсний тодорхойлсон зорилтод маань нөлөөлөхгүй гэдэг тодорхойлолтыг гаргаж өгснөөр зах зах зээлийг илүү тодорхой, давхардсан бүртгэлгүй болгож байгаа юм.

Тэгэхээр хөрөнгө оруулагчдыг эрсдэлээс хамгаалах чухал үүрэгтэй тодорхойлолтуудыг гаргаж өгөхөөр байгаа. Суурь судалгаануудыг хийж байгаа гэсэн үг.

Газрын зохион зохицуулалтын хувьд бэлчээр, ой, тариалангийн талбай, намгархаг газар зэрэг эко системд шингэж байгаа кредитүүдийг тооцох зохион байгуулалтыг газрын зохион байгуулалтаар оруулж өгч байгаа юм. Ялгаж өгч байгаа гэсэн үг. Товчхондоо хэлэх юм бол.

Эдийн засгийн эргэлтэд сул бэлчээр байгаа. Тийм ээ. Намгархаг газрууд байгаа.

- ➔ Бэлчээрийн талбай, тариалангийн талбай зэргийг аль алийг нь яаж ашиглах юм бэ.
- ➔ Хэн энэ үр ашгийг нь хүртэх юм бэ.
- ➔ Карбоныг хэрхэн тооцох юм бэ –

-гэдгийг бол маш тодорхой хуульд зааж өгч байгаа.

Тэгээд энэ хуулийг дагаж гарч байгаа журмууд дээр үүнийг нэлээд дэлгэрэнгүй тодорхойлж өгөхөөр байгаа.

Л.Мөнхбаясгалан: Сүүлийн асуулт.

Хуулийн 31.3 дээр 22.7 гэж хэсэг байгаа байхгүй юу. 22.7 гэж энэ хууль дээр байхгүй л байна л даа. С.Ганбаатар гишүүний асуултад хариулья.

Ш.Батбаяр: Энэ төслийн явцад техникийн алдаа гарсан. Одоо зассан байгаа юм байна.

22.6 байгаа юм байна. 22.6 буюу хүлэмжийн хий ялгаруулдаг салбарт ногоон санхүүжилт, зээл олгох, хөрөнгө оруулалт хийхдээ байгаль орчин, нийгэм, эдийн засгийн эрсдэлийн үнэлгээг харгалзана гэсэн заалт байгаа юм байна. 22.6. Техникийн алдаа гарсан байгаа юм байна.

Л.Мөнхбаясгалан: С.Ганбаатар гишүүн тодруулах уу? С.Ганбаатар гишүүний микрофоныг нээе.

С.Ганбаатар: 22.6-г ойлголоо.

Ингээд чуулган дээр яривал бид чуулгандаа үл хүндэлсэн юм шиг болох гээд байдаг. Ингээд ярьсан нь зөв байна. Баярлалаа.

Тэгээд 23.3.8 дээр тухайн төсөл хэрэгжих орон нутгийн иргэдтэй урьдчилан зөвлөлдөж санал авсан байх гэдэг дээр зүгээр нэг зөвлөлдөөд л хаячих уу, эсвэл заавал зөвшөөрлийг нь авсан байх уу гэдгийг нэг тодруулаад өгөөч.

Одоо манай Уул уурхайн яам чинь зөвлөлдсөн, саналыг нь авсан гээд л өөрийнхөөрөө явчихдаг.

Л.Мөнхбаясгалан: Индрийн микрофоныг өгье.

Ш.Батбаяр: Иргэдийн дэмжлэгийг авах шаардлагатай. Тэгээд хурлын тэмдэглэл авна гэсэн үг. Хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Үнэлгээний хууль дээр байдаг шиг иргэдийн хурлын тэмдэглэлийг авна гэсэн үг.

Л.Мөнхбаясгалан: Гишүүдэд асуулт асууж, хариулт авч дууслаа. /алх цохив/

Хууль санаачлагчийн танилцуулгатай холбогдуулан санал хэлэх гишүүн байна уу? Санал хэлэх гишүүн байхгүй байна. /алх цохив/

Гишүүд санал хэлж дууслаа. /алх цохив/

Одоо санал хураалт явуулна. Гишүүд санал хураалтдаа бэлтгэнэ үү.

Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт. /алх цохив/

56.3 хувиар санал дэмжигдлээ.

Хамт өргөн мэдүүлсэн Агаарын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт. /алх цохив/

56.3 хувиар санал дэмжигдлээ.

Авто замын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт. /алх цохив/

56.3 хувиар санал дэмжигдлээ.

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт. /алх цохив/

Төхөөрөмж гацсан тул санал хураалтыг хүчингүй болгож өгнө үү? Санал хураалтыг хүчингүй болгохоор санал хураая. /алх цохив/

56.3 хувиар горимын саналыг дэмжлээ. Санал хураалт хүчингүй боллоо.

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт. /алх цохив/

56.3 хувиар санал дэмжигдлээ.

Барилгын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт. /алх цохив/

56.3 хувиар санал дэмжигдлээ.

Байгаль орчныг хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт. /алх цохив/

56.3 хувиар санал дэмжигдлээ.

Гамшгаас хамгаалах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт. /алх цохив/

56.3 хувиар санал дэмжигдлээ.

Олон улсын гэрээний тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт. /алх цохив/

56.3 хувиар санал дэмжигдлээ.

Тариалангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт. /алх цохив/

56.3 хувиар санал дэмжигдлээ.

Хот байгуулалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт. /алх цохив/

56.3 хувиар санал дэмжигдлээ.

Статистикийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт. /алх цохив/

56.3 хувиар санал дэмжигдлээ.

Эрч эрчим хүчний хэмнэлтийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт. /алх цохив/

56.3 хувиар санал дэмжигдлээ.

Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хуулийг дагаж мөрдөх тухай журмын тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт. /алх цохив/

56.3 хувиар санал дэмжигдлээ.

Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулах гишүүнээр хэн байх вэ? С.Одонтуяа гишүүн.

Байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд С.Одонтуяа гишүүн танилцуулна.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан хаасныг мэдэгдье. /алх цохив/

Байнгын хорооны гишүүд ажлын хэсгийнхэнд баярлалаа.

Хуралдаан 1 цаг 23 минут үргэлжилж, 18 цаг 05 минутад өндөрлөв.

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ**

Ц.АЛТАН-ОД